

УДК 82-343

DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-78-99

## **Миф о рождении Гесера в мир (сравнительный анализ с текстом «Рамаяны» и биографией Будды)**

*Цеценбат*<sup>1</sup>,

*Евдокия Эрендженевна Хабунова*<sup>2</sup>

<sup>1</sup> Институт национальных литератур Китайской академии общественных наук (5, Цзяньго мэнь нань дацзе, 100732 Пекин, КНР)

Доктор филологии, профессор

<sup>2</sup> Калмыцкий государственный университет им. Б. Б. Городовикова (д. 11, ул. Пушкина, 358000 Элиста, Российская Федерация)

доктор филологических наук, профессор

E-mail: khabunova@mail.ru

© КалмНЦ РАН, 2020

© Цеценбат, Хабунова Е. Э., 2020

**Аннотация.** Во всех главах монгольского «Гесера» присутствует мотив рождения героя, структура которого включает несколько сюжетных элементов: Хормуста ради спасения живых существ отправляет на землю одного из своих сыновей; на земле у подножия «обо» совершается предсказание о рождении Гесера; о непорочном зачатии и о необычном рождении героя. На основе подобных элементов выстроен сюжет рождения героя и в тибетском «Гесере». Сходство содержания мотива рождения героя в тибетском и монгольском эпических сказаниях о Гесере не вызывает сомнения, но вместе с тем есть и заметные различия. В этих эпических текстах присутствуют общие для богатырских сказаний мотивы бездетных престарелых родителей, выпрашивание ребенка у божества, непорочное зачатие и необычное рождение героя. По такой же схеме выстроен мотив рождения героя в индийской «Рамаяне», но содержательная часть имеет свою отличную специфику. При анализе текста биографии Будды выясняется, что мотив рождения Будды также выстроен на вышеуказанных элементах. В данной статье дан сравнительный анализ содержательной части мотива рождения героя в монгольском «Гесере»,

тибетском «Гесере», индийской «Рамаяне» и в биографии Будды Шакьямуни.

**Ключевые слова:** мотив рождения героя, монгольский «Гесер», тибетский «Гесер», «Рамаяна», биография Будды

**Благодарность.** Исследование выполнено при финансовой поддержке РФФИ и Академии общественных наук Китая в рамках научного проекта № 19-512-93002 «Фольклор народов Шелкового пути: ойрат-монголы Китая и калмыки России (от сказки к эпосу)». Материалы статьи апробированы на Международной научной онлайн-конференции «Монголоведение в начале XXI в.: современное состояние и перспективы развития – II», проведенной при финансовой поддержке РФФИ (проект № 20-09-22004) и частичной поддержке гранта Правительства РФ (№ 075-15-2019-1879).

**Для цитирования:** Цеценбат, Хабунова Е. Э. Миф о рождении Гесера в мир (сравнительный анализ с текстом «Рамаяны» и биографией Будды) // Бюллетень Калмыцкого научного центра РАН. 2020. № 2. С. 78–99. DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-78-99

UDC 82-343

DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-78-99

## **The Myth of Geser's Birth into the World (Comparative Analysis with the Ramayana Texts and the Biography of Buddha)**

*Tsetsenbat<sup>1</sup>, Evdokia E. Khabunova<sup>2</sup>*

<sup>1</sup> Institute of Ethnic Literature, Chinese Academy of Social Sciences  
(5 Jiannei Dajie, Beijing 100732, People's Republic of China)  
PhD, professor

<sup>2</sup> Kalmyk State University named after B.B. Gorodovikov  
(11, Pushkin St., Elista 358000, Russian Federation)  
Dr. Sc. (Philology), Professor  
E-mail: khabunova@mail.ru

© KalmSC RAS, 2020

© Tsetsenbat, Khabunova E. E., 2020

**Abstract.** All the chapters of the Mongolian “Geser” contain the theme of the hero’s birth the structure of which consists of several narrative elements: Khormusta sends one of his sons to the Earth in order to save the living beings; the prophesy about Geser’s birth is made at the foot of “obo” on the Earth; the immaculate conception and the uncommon birth of the hero. The same narrative elements are used in the birth of the hero’s subject in Tibetan “Geser”. There are doubtless similarities in the pattern of hero’s birth both in Tibetan and Mongolian eposes, however, there are visible differences. In these epic texts there are topics common to all heroic legends: childless elderly parents, begging a child from gods, an immaculate conception and an unusual birth of the hero. The same structure is used in the birth of the hero in the Indian “Ramayana”, however, the content has its distinct peculiarity. The analysis of the biography of Buddha showed that in the topic of Buddha’s birth the same narrative elements are used. The study gives a comparative analysis of the content of the hero’s birth in Mongolian “Geser”, Tibetan “Geser”, Indian “Ramayana” and the Buddha Shakyamuni’s biography.

**Keywords:** topic of hero’s birth, Mongolian “Geser”, Tibetan “Geser”, “Ramayana”, Buddha’s biography

**Acknowledgement.** The research was funded by RFBR and Academy of Social Sciences of China within the scope of research project № 19-512-93002 “The Folklore of the peoples of the Silk Road: Oirat-Mongols of China and Kalmyks of Russia (from fairy tale to epos)”. The article was presented at the international scientific online conference “Mongolian Studies at the beginning of the 21<sup>st</sup> century: Current State and Development Prospects – II”, held with the financial support of RFBR (project № 20-09-22004) and partial support of the Russian Government Grant (№ 075-15-2019-1879).

**For citation:** Tsetsenbat, Khabunova E.E. The Myth of Geser’s Birth into the World (Comparative Analysis with the Ramayana Texts and the Biography of Buddha). *Bulletin of the Kalmyk Scientific Center of the RAS*. 2020. No. 2. Pp. 78–99. DOI: 10.22162/2587-6503-2020-2-14-78-99

## 1. Хүслэн нэрт овоон дээрх чуулган

Хэн бүхний мэдээжээр Гэсэрийн ертөнцөд мэндэлсэн үлгэр монгол «Гэсер»-үүдийн хамгийн эхэнд гардаг бөгөөд нэлээд адилаар өгүүлэгдэнэ. Агуулга бүтцийн хувьд дөрвөн хэсгээр бүрэлдэнэ.

1. Бээжингийн модон барын «Гэсэр», «Номч хатны Гэсэр», «Устын зуугийн Гэсэр», «Заяын Гэсэр», «Ордос Гэсэр» зэрэгт Шаг-жамуни бурхан нирвааны дүр үзүүлэхийнхээ өмнө ертөнц дэлхий ирээдүйд самуун болох, хүчтэй нь хүчгүйгээ барьж идэх, гөрөөсөн өөр зуураа нэг нэгнийгээ барьж идэх болохыг айлдан мэдээд, таван зуун жилийн дараа гурван хөвгүүнийхээ нэгнийг ертөнцөд илгээ гэж Хурмаст тэнгэрт зарлиг болсон тул, Хурмаст тэнгэр хөвгүүн Үйлбүтээгчээ ертөнцөд буулгахаар болсныг өгүүлнэ.

2. Дараа нь тухайн үеийн ертөнцийн хар тэргүүт хүнээс бус хамаг амьтан Хүслэн нэрт овоон дээр чуулган чуулсан нэгэн үйл ажиллагааг өгүүлдэг бөгөөд хамаг түрүүнд чуулган болсон учир шалтгаан хийгээд чуулганы агуулгыг ингэж өгүүлсэн байна: Түүний хойно ертөнцийн цаг самуун болсонд хар тэргүүт хүнээс бус нисэх шувуун бүгдээр Хүслэн нэрт овоон дээр чуулган чуулав. Арьяа Алмагарь охин Цагаан тэнгэр хэлэв: “Ай, гурван төлгөч нар, энэ ертөнцийн цаг самуун болсныг даралгалан чадах хаан төрөх буюу, үгүй буюу? төлгө орхиж үз” гэв. Тэгээд Мова гүүш, Данбо нэрт төлгөч, Оваа Гүнжид гурван төлгөч төлгө орхисонд Гэсэр Гарав Донров нэртэй хөвгүүн төрөх бий, эх нь Гэү баяны охин Гэгсэ Амаржил болох бий, эцэг нь энэ Оваа Гүнжид болох бий гэсэн төлгө буусанд охин тэнгэр бас, та нарын төлгө үнэн үү худал уу хүлээж мэдье гээд Хүслэн нэрт овоон дээр хүлээж гэнэ<sup>1</sup>.

3. Тэр төлгийг сонссон Тусаа, Дүнсэр, Лингийн хүмүүс Гэү баянд цэрэг мордож очсон, Цотон ноён Гэгсэ Амаржилыг ах Сэнлон өвгөнд эхнэр болгон өгсөн, Гэгсэ Амаржил ууланд түлээ түүж яваад хувилгаан шувуу болон хувилж ертөнцөд эх болох хүн хайж явсан тэнгэрийн хөвгүүн Үйлбүтээгчтэй тааралдсан, нэгэн их хүнтэй тааралдаж мэдээ алдан унасан, дараа өглөө нь мөрөөр нь мөшгиж нэг их агуйн хөндийд орсон ба тэр агуй дотор нэгэн аварга эр саатаж, өчигдөр шөнө алжаахын ихээр алжаав гэж хэлэхийг сонсоод айн эмээж харьж ирээд жирэмсэлснийг өгүүлдэг.

4. Гэгсэ Амаржилын учрал тохиолыг үзсэний дараа гурван зуун өөр хэлтэн амьтан тархав, Арья Алмагарь охин Цагаан тэнгэр тэн-

---

<sup>1</sup> Охин тэнгэрийн хэлсэн сүүлийн энэ үг ордос «Гэсэр»-т бий.

гэрт гарав, Мова гүүш, Данбу нэрт төлгөч Хүслэн нэрт овоон дээр оров, тэд бүгд төлгөч нарын үг үнэн болов уу гэж хүлцэж билээ, үнэн гэж тархав гэж өгүүлдэг. Энэ өгүүлэмжид гурван төлгөчөөс хоёрыг нь дурдаад нөгөө уулсын хаан Оваа Гүнжидийг дурдсангүй байх нь сонирхолтой бөгөөд Хүслэн нэрт овоон дээрх чуулганд зарим тэнгэр, уул усны эзэд сахиус ч залран саатсан гэдгийг мөн өгүүлэмж бас үзүүлж байна.

5. Удалгүй Гэсэрийн эх нярайлах болж, Гэсэрийн гурван эгч, Гэсэрийг төрүүлсэн ба дараа өглөө нь болоход гадна байсан мал ахуй нь төллөснийг өгүүлнэ.

Үлгэрийн бүтэц хийгээд агуулга, тушаах гэсэн гол санаанаас үзвэл, бурхны зарлигаар Үй бүтээгч ертөнцөд буухаар нэгэнт шийдсэний дараа шууд Тусаа, Дүнсэр, Лингийн ноёдын үлгэрт шилжиж, Гэгсэ Амаржил хээр явж байгаад аварга хүнтэй тааралдаж жирэмсэн болсон үйл хэргийг өгүүлж болох атал дунд нь ертөнцийн хар тэргүүт хүнээс бус хамаг амьтан “Хүслэн нэрт овоон” дээр чуулсан үлгэр оруулж байна. Энэ үлгэр үйл явдал чухам ямар учир утгатай байна? Ямар ирэл гаралтай вэ гэдэг нь сонирхолтой. Энэ асуудлыг тодорхойлох гэвэл эрхбиш түвд “Гэсэр”-тэй харьцуулж үзэх хэрэгтэй.

## **2. Түвд «Гэсэр»-тэй харьцуулах нь**

Түвд Гүйдэ «Гэсэр» хийгээд Түвдээс орчуулагдлаа гэгддэг монгол «Лин Гэсэр» буюу «Замлин Сэнчиний намтар» хоёр адилхан эхлэлээр эхэлдэг бөгөөд монгол «Гэсэр»-үүдтэй адилаар Гэсэр ертөнцөд мэндэлсэн үлгэрээр эхлэлээ болгодог:

1. Урьд тоолшгүй галбын тэртээ тэнгэрийн орны хаан Чамба Гарав, хатан Бумжин Жалму хоёр Сайн үйлт, Цагаан үйлт, Үйл бүтээгч хэмээх гурван хөвгүүнтэй байжээ. Тэр цагт дэлхий дахиныг догшин шумну эзлэх болсонд, бурхан бодисадваа нар билгийн нүдээр үзэж, чухал зөвчлөөд, хязгаарын дөрвөн шумнуг доройтуулан дарах хүчит хувилгаан нэгийг эс буулган илгээвээс болохгүй гээд Эсэруа хурмастын отгон хөвгүүн Үйл бүтээгчийг илгээвээс сайн хэмээлцэж, эцэг хаанд нь шаардах бошиг өгсөнд, Эсэруа хурмаст отгон хөвгүүнээ ертөнцөд буулгахаар боллоо

гэдэг. Энэ бол монголоор орчуулсан «Лин Гэсэр» дэх өгүүлэмж [Замлин сенчиний... 1959: 2]. Түвд Гүйдэ «Гэсэр»-т бол Хоньсом бодисадваа Эсэруа тэнгэр хоёр зөвчлөн уг шийдвэрийг гаргалаа гэж өгүүлдэг [王沂暖、华甲翻译 1981: 1]. Энэ хэсэг нь монгол Гэсэрийн өгүүлэмжтэй үндсэн үйл явдлын талаар нэлээд адилавар. Адилгүй зүйл нь монгол «Гэсэр»-т бол Шагжамуни бурхан нирваан дүр үзүүлэхийн урьд Хурмаст тэнгэрт зарлиг болсон тэр зарлигаар Үйл бүтээгчийг ертөнцөд буулгадаг бөгөөд энэхүү үлгэрийн ирэлтийн тухай миний бие ««Гэсэрийн тууж»-д бурхны зарлигийн учир» хэмээх өгүүлэлд [Цэцэнбат 2015: 71–76] нэгэнт бурхны намтрын үлгэрээс ирэлтэй хэмээн нотолсон билээ.

2. Залгаад Үйл бүтээгч хувилгаан шувуунд хувилан ертөнцийн орныг эргэж эх болох хүнийг хайсан үйл явдлыг өгүүлнэ. Хэдийгээр үлгэр үйл явдлын хувьд нэлээд зөрүүтэй боловч монгол «Гэсэр» дэх Гэгсэ Амаржил хээр явж байгаад хувилгаан шувуутай тааралдсан үйл явдалтай тохиролцож байна.

3. Дараа нь тухайн цагт ертөнцийн оронд ямар үйл явдал болж байсныг өгүүлнэ:

Лингийн орны их хаан Дагварал хатан Нанжинма хоёроос Сэндэнраж, Кали Комчон, Цотон Даг, Чавадкуд Даг, Брайсан Даг хэмээх таван хөвгүүнтэй бөгөөд өсөж өөлэй болсных нь сүүлээр тус бүр хатан буулган өгч хувь хөрөнгө салгаж өгчээ. Тэгээд ахмад хөвгүүн Сэндэнражид Кун газрын хааны авхай Кугса Лаамуг хатан болгож залсан боловч Кугса Лаамугаас хүүхэд үл төрөхийн учир түүний охин дүү Нандигмаг дэд хатан болгон залсан боловч бас ч хөвгүүн олдохгүй тул хамаг уулсын хаанд залбиран үр гуйжээ. Тэгж байтал нэгэн өглөө, нэгэнт тавь хүрсэн Кугса Лааму сарлагийн хүрээнд байтал огторгуйгаас өнгөт үүл бууж түржигнэх чимээ гарсанд яаран дээш харж үзсэнд элдэв эрдэнээр чимэглэж хив торго асгаруулсан нэгэн хөвгүүнийг олон дагинас өргөлцөн огторгуйн замаар бууж ирэхийг харахын сацуу ухаан мэдэлгүй унаж, түүнээс болж хатан Кугса Лааму бие жирэмсэн болж, Гэсэр хаан ертөнцөд мэндэллээ гэж өгүүлдэг. Энэ бол монгол «Лин Гэсэр» дэх өгүүлэмж [Замлин сенчиний... 1959: 3–5]. Түвд Гүйдэ «Гэсэр»-т Сэндэнраж Кугса Лааму, Гандигма, Нандигма гурван

хатан авсан боловч үр хүүхэд ер олодохгүй болохоор уулсын хаан хийгээд Эсэруа тэнгэрээс үрийн хутаг гуйсан гэж бий. Харин хатан Кугса Лааму бие жирэмсэн болсон шалтгааныг монгол «Лин Гэсэр» дэх дээр дурдсан үлгэртэй нэгэн адил өгүүлж байна [王沂暖、华甲翻译 1981: 10].

Энэ үлгэр монгол «Гэсэр»-ээс нэлээд зөрүүтэй. Үүнд ертөнцийн хамаг амьтан Хүслэн нэрт овоон дээр цуглаж гурван төлгөч төлгө орхисон, тэр төлгө ёсоор Гэсэрийн эх жирэмсэлсэн үлгэр гараагүй байна. Үүний оронд хэдийгээр маш дөхөмхөн тушаасан боловч түвд Гүйдэ «Гэсэр»-т өтөлтөл үр хүүхэдгүй Сэндэнраж хаан хатан хоёр уулсын хаан хийгээд Эсэруа тэнгэрт залбирснаар үрийн хутаг заяалаа хэмээх өгүүлэмж бий. Монгол «Лин Гэсэр»-т бол хаан хатан хоёр хамаг уулын хаанд залбиран үрийн хутаг гуйснаар Гэсэр хаан ертөнцөд мэндэлснээр өгүүлж байна.

Түвд «Гэсэр» дэх уулсын хаантай тохиролцох дүр монгол «Гэсэр»-т байх бөгөөд түүнийг уулсын хаан Оваа Гүнжид хэмээдэг. Түвд «Гэсэр»-т уулсын хаанаас үрийн хутаг гуйж байхад монгол Гэсэрт уулсын хаан Оваа Гүнжид төлгө барьж Гэсэрийн мэндлэхийг урьдчилан мэдээлдэг. Түвд монгол хоёр эх дэх уулсын хааны тохиролцоо нь чухам монгол «Гэсэр» дэх Хүслэн нэрт овооны чуулганы учир утгыг тайлах түлхүүр нь юм.

Учир нь түвд эхтэй харьцуулбал монгол эхүүд дэх Хүслэн нэрт овоон дээр болсон чуулган нь чухамдаа уулсын хаанаас үрийн хутаг гуйх учиртай чуулган аж. Гэхдээ өтөлтлөө үр олоогүй хаан хатан хоёр, уулсын хаад хийгээд Эсэруа тэнгэрт даатгаж үрийн хутаг гуйсан энэхүү үйл хэргийг бээжин барын «Гэсэр», «Номч хатны Гэсэр», «Заяын Гэсэр», «Устын зуугийн Гэсэр» болон ордос «Гэсэр» зэрэгт баахан балархайшуулан өгүүлсэн шинжтэй. Хэдий тийм боловч ертөнцийн амьтад «Хүслэн нэрт овоон дээр чуулган чуулж», «Энэ ертөнцийн цаг самуун болсныг даралгалан чадах хаан төрөх буюу, үгүй буюу» гэж төлгө орхиулж байгаагаас, хаан ор суух хөвгүүн хүсэж уул овоо тахиж байгаа гэдэг нь илхэн байна. Тэгээд ч хүмүүсийн цугларч байгаа овоо нь бас «Хүслэн нэрт овоо» нэртэй байх нь хаан төрөө барьж ертөнц дахиныг амаржуулах хөвгүүн төрөхийг хүссэн тэрхүү санаагаа давхар цухуйлгаж байгаа хэрэг юм.

Тэгвэл, «Гэсэр» дэх үрийн хутаг гуйсан үлгэр нь монгол үлгэр туулийн уламжлал дахь үрийн хутаг гуйдаг өгүүлэмжтэй ямар холбоотой, ямар ялгаатай болохыг чанагшид нягтлах хэрэгтэй.

### **3. Үрийн хутаг гуйх өгүүлэмж монгол үлгэр туульд**

Түвд «Гэсэр»-ийг судалсан эрдэмтэн Ли Ляньрүн, түвд «Гэсэр»-т Хоньсом бодисадваагийн сануулгаар Эсэруа тэнгэр хөвгүүнээ ертөнцөд буулгасан үйл явдал хийгээд үр хүүхэд олдохгүй хаан хатан үрийн хутаг гуйснаар хаан хөвгүүн төрсөн үйл явдал хоёр давхцаж байгаа ба сүүлийнх нь улам баларч байгааг ажиглаад, үрийн хутаг гуйдаг нэн эртний өгүүлэмжийг бодисадваагийн сануулгаар Эсэруа тэнгэр хөвгүүнээ ертөнцөд буулгасан хожим үеийн өгүүлэмжээр засаж өөрчилсөн ба энэхүү засвар өгүүлэмж нь улам улам газар авч, түрүүчийн өгүүлэмж нь балрахад хүрчээ гэж заагаад, үрийн хутаг гуйдаг үлгэр үйл явдал Европ, Азийн үндэстнүүдийн үлгэр туулийн уламжлалаас ирэлтэй гэж үзсэн байдаг [李连荣著: 27].

Үнэхээр ертөнцийн хүн амьтан Хүслэн нэрт овоонд цугларан, ертөнцийн самууныг даралгалан чадах хаан хөвгүүн төрөх эсэхийг төлгөдүүлж байгаа энэ үлгэр үйл явдал бол монгол тууль болон алтай хэлт үндэстнүүдийн баатарлаг туулийн эхэнд хааяа гардаг өтөлтлөө үр олоогүй хаан хатан хоёр уул усны эзэн сахиус хийгээд дээд тэнгэрт тахил өргөн үрийн хутаг гуйдаг эхлэлийн загварыг бага зэрэг өөрчилсөн хэлбэр мөн байна. Алдарт монголч эрдэмтэн Вальтер Хайсигийн «Хад чулуунаас мэндлэх ба уулын шүтлэг» хэмээх өгүүлэлд ийм туулийг нэлээд дурдсан байдаг. Тухайлбал Монгол улсын баруун аймгийн Улаангомоос тэмдэглэсэн «Алтай хайлах» туульд, хөгширтлөө үр хүүхдийн бараа үзээгүй алтайн эзэн бурхан хаан, гучин хоёр төлгөчөөр төлгөдүүлсэнд, Атаа тэнгэр, Алтай Хангайг арван гурван гүүгээр тахиж, дээд эцэг тэнгэрт нэг тэмээ, дор этүгэн эхэд нэг бодонгийн тахил өргөвөл хаан төрийн жолоог барих хөвгүүнтэй болно гэж мэргэлсэн бөгөөд тэр ёсоор нь гүйцэтгэсэнд үнэхээр хөвгүүнтэй болсон гэж гардаг. Үүнтэй адилаар алтай урианхайн туульч Өлзийн Буяны хайлсан «Бужин даваа хаан», дөрвөд туульч Парчингийн хайлсан «Данихүрэл» зэрэг аль

олон тууль бүр ийм эхлэлтэй байдаг. Киргиз тууль «Манас», алтайчуудын тууль «Ай мэргэн», «Алтан күш», «Хан тэнгэр» зэрэгт бүр ийм өгүүлэмж гардгийг ч энэ өгүүлэлд дурджээ [海希西著、赵振全译 1984: 164–181]. Үүнээс гадна, «Цагаан далай нутагтай Савхалт хааны хөвгүүн» туульд ч үрийн хутаг гуйсан өгүүлэмж гардаг [Хятадын нийгмийн ШУА-ийн...].

Дээд тэнгэр бурхан сахиусаас үрийн хутаг гуйдаг өгүүлэмж монгол баатарлаг үлгэрт нэн олон тохиолдохыг эрдэмтэн Дамринжав ажиглаад «Баатарлаг үлгэрт үр хүүхэдгүй эмгэн хөгшин (хаан хатан) өндөр уул хайрхан (Цагаан аав, тэнгэр, лам нар)-д хүрч мөргөөд тэднээс үрийн хутаг гуйж байгаагаар үлгэрийн үйл явдал эхэлдэг <...> ийм өгүүлэмжүүд баатарлаг үлгэрт олон байхад харин баатарлаг туульст элбэг тохиолддоггүй» [Ринчиндорж 2007: 1203] гэж зааж гаргажээ. Монгол баатарлаг үлгэрийг үйл явдлаар нь дан үйл явдалтай баатарлаг үлгэрийн 4 зүйл, нийлмэл үйл явдал бүхий баатарлаг үлгэрийн 21 зүйл, нийт 25 зүйлд ангилсны дотор 8 зүйл нь бүр үрийн хутаг гуйсан үйл явдалтай аж [Дамринжав 2006: 62–63]. Энэ нь монгол баатарлаг үлгэрийн 1/3 нь уул хайрхан (тэнгэр бурхан, Цагаан аав, лам нар)-аас үрийн хутаг гуйсан үйл явдалтай гэснийг харуулж байна, мөн ч монгол баатарлаг үлгэрт иймэрхүү үлгэр үйл явдал тун элбэг бөгөөд түгээмэл байдгийг харуулж байна.

Дамринжавын дүгнэснээр, үрийн хутаг гуйсан үлгэрийн үйл явдал нь дараах сонгодог хэв загвараар өрнөдөг:

1. Эмгэн өвгөн хоёр үр хүүхэдгүй. Эмгэн өвгөн (хаан хатан) хоёр нас нь хэдэн зуу хэдэн мянга, хэдэн түм буюу хэдэн бум сая хүртэл үр хүүхэд гарахгүйд маш зовдог.

2. Тэнгэр, уул хайрхныг тахиж, эсхүл Цагаан аав, даяанд суусан лам, дээдсийн гурван сахиусаас үрийн хутаг гуйдаг.

3. Тэнгэр, уул хайрхан зэргээс хайрласан үр хүүхэд нь төрөхдөө нэг гартаа цус, нөгөө гартаа чулуу, төмөр, саадгийн сум зэргийг атгаж төрдөг.

4. Сая төрсөн тэр хүүхэдийн хүйсийг юугаар огтолсон ч тасардаггүй, чулуугаар буюу аавынх нь мухар хар хутгаар огтлоход сая тасардаг.

5. Тэр хүүхэд нь нэг хонож нэг иргийн арьсанд багтахгүй, хоёр хонож хоёр иргийн арьсанд багтахгүй маш түргэн өсдөг... [Дамринжав 2006: 67–68].

Үүнээс үзвэл, монгол баатарлаг тууль хийгээд баатарлаг үлгэрт ертөнцийн орны ямар нэгэн хаан хатан хоёр дээр тэнгэрээс үрийн хутаг гуйсан үйл явдал гардаг боловч, түүний сонгодог загварт тэнгэрийн орны бурхан тэнгэр нар хэнийг ертөнцөд илгээх тухай зөвтөлцдөг үйл явдал гардаггүй байна. Иймээс тэнгэрийн орны үлгэрийн хэсэг нь өөр ирэл гаралтай бололтой байна.

Анхаарууштай нь, цөөн зарим монгол баатарлаг үлгэр хийгээд баатарлаг туульд үүнээс өөр шиг үрийн хутаг гуйсан үлгэр гардаг. Жишээлбэл, бум сая настай Бусар алдар хаан үр хүүхэдгүй учраас дээр Замбуутивд хүрч бурхан багшаас үрийн хутаг гуйсанд гурван гаталганаас гаталж чадвал үр хүүхэдтэй болж чадна гэжээ. Тэр ёсоор нь гурван бэрх үйлийг бүтээгээд үр хүүхэдтэй болдог [Дамринжав 1997: 130–131]. «Ганц төрсөн галдамт улаан баатар»-г, дунд Замбуутивд хаан тогтохгүй учраас Саргин цагаан түшмэл дээд тэнгэрт гарч хаан хурмастаас ертөнцөд хаан болох хүн гүйсанд Хурмаст гурван хөвгүүнээр тийм хүн эрүүлсэнд отгон хөвгүүн нь хаан чулуун аавтай, хатан чулуун эхтэй, үрэл чулуун эгчтэй, ганц төрсөн Галдамт улаан баатрыг олж ирсэнд, хаан Хурмаст тэр баатрыг ертөнцийн хаан болно гэжээ. Тэгэхэд тэр баатар Хурмаст тэнгэрээс гурван эгчийн сахил, хүнд гартай савар, мухар хар илд аваад дунд Замбуутивд хаан суухаар буусан гэдэг [Дамринжав 1997: 151–168]. «Халзан улаан баатар» хэмээх үлгэрт бол харин Шагжамуни бурхан дунд ертөнцөд хаангүй байхыг үзээд хаан чулуун аавтай, хатан чулуун эхтэй, үрэл чулуун эгчтэй гарди хар халзан морьтой Халзан улаан баатрыг томилж хаан суулгасан гэж гардаг [Дамринжав 1997: 169–176]. Адил нэртэй хоёр хувилбарт ч адаливтар өгүүлнэ [Дамринжав 1997: 171–196].

Монгол баатарлаг туульд бас иймэрхүү үрийн хутаг гуйсан үйл явдал бий. Жишээлбэл, урианхай туульч Авирмэдийн хайлсан «Талын хар бодон» туульд, доvon хар бөх өтөлтлөө үр хүүхэдгүй учраас хан Хурмаст тэнгэр болон луусыг дуудан уй гашуу болов. Тэгээд Алтай өргөн нутгаа харахаар явж байтал талын хар бодон

гэдэг баатар Хурмаст тэнгэрийн зарлигаар хүрч ирээд довон хар бөхтэй танилцаж хөвгүүн нь болдог [Ринчиндорж 2007: 266–282]. Адилхан урианхай туульч Чойсүрэнгийн хайлсан «Талын хар бодон» туульд талын хар бодон хан Хурмаст эцэг болон луус эхийнхээ зарлигаар үр хүүхэдгүй довон хар бөхийн хөвгүүн нь боллоо гэдэг [Ринчиндорж 2007: 45–56]. Мөн Чойсүрэнгийн хэлсэн «Баян цагаан өвгөн» туульд энэхүү үйл явдал гарах бөгөөд өгүүлэх нь, таван хан Хурмаст дунд замбуутивийг эргэж яваад баян цагаан өвгөн, бумын улаан хатан хоёр үр хүүхэдгүй байхыг үзээд отгон Хурмастыг үр нь бол гэж гэрийнх нь баруун цамхаригаар нь таван өнгийн солонго татуулан үр заяалгаж өгөөд дөрвөн алтан толгойтой хун болон огторгуйд өөд болжээ гэнэ [Ринчиндорж 2007: 1203]. Баяд туульч Парчингийн хэлсэн «Данихүрэл» туульд, гурван зуун далан настай дагинийн өвгөн далай хаан хийгээд Мөсөн гэрэл хатан хоёр үр хүүхэдгүй учир хатан нь далай хааныг, мөсөр тувхан хангайн оргил дээр алтан мөнгөн хоёр суварга барьж арван гурван сан тавьж ачит гурван эрдэнэд итгэмжилж, алтан дэлхийн эздээс, Эсэруа Хурмаст тэнгэр нараас орон сахих хөвгүүн хайрла гэж өргөж мөргөж ир гэж явуулсанд далай хаан тэр ёсоор гүйцэтгээд явж байтал, есөн өргүү биетэй, хасаг туяхан заан шаргал морьтой, хараацай хар сахалтай, цаснаас цагаан самсаатай, цуснаас улаан халхтай хар улаан баатар ирж, алтан мөнгөн хоёр суварга дээр зогсож, ачит гурван эрдэнэ, аврагч номын сахиусан адистэдтай олон орны эзэд бүгдээр зөвлөж танд нэг сайн хөвгүүн хайрлавай гээд цааш таттал нэр чинь хэн гэхэд миний нэр уртын эзэн Цасчихэр гээд үл үзэгдэн одсон гэнэ. Гэртээ хариад тэр зарлигийг хатандаа хэлсэнд хатан нь, надад бас тийм зарлиг соёрхоод үзэгдэлгүй одов гэжээ. Тэгээд хатан жирэмсэлж, өдөр хоног нь гүйцэхээр алтан суваргын үүднээс далан давхар хялар хар будан татаж долоон өнгийн солонго татаад ирэхэд хатнаас алтан цээжтэй мөнгөн бөгстэй шил магнайтай цой хүрэл хүйстэй хөвгүүн мэндэлсэнд хүйсийг нь хэрчих ирт мэс бүр даадаггүй, тэр нялх хөвгүүн нь өвөө аавын алмаст хар болд илдээр хэрч гэсэнд сая хүйсийг нь хэрчсэн гэнэ [Парчин 1972: 196–201].

Эдгээр жишээнээс үзэхэд монгол баатарлаг үлгэр хийгээд баатарлаг туульд үр хүүхэдгүй хаан хатан хоёр тэнгэр уул хайрхнаас үрийн хутаг гуйхад үнэхээр хоорондоо зөвчилж, эсвэл тэнгэр Хурмаст өөрөө эзэн мэдэж нэгэн сахиусыг тэр хаан хатны хөвгүүн бол гэж томилж явуулдаг үлгэр үйл явдал байсан юм байна. Үүний дотор зарим нь «Гэсэр»-ийн нөлөө авсан шиг байна. Тухайлбал, өтөлтлөө үргүй хаан хатан хоёртоо Хурмастын зарлигаар нэгэн баатар ирж хөвгүүн нь болдог нь «Гэсэр» дэх өгүүлэмжтэй нэгэн адил байхаар барахгүй, «Ганц төрсөн Галдамт улаан баатар»-т Саргин цагаан түшмэл гэж гардаг нь «Гэсэр» дэх Царгин өвгөнтэй тохиролцож байна. Галдамт улаан баатар хаан Хурмастаас гурван эгчийн сахил авч ертөнцөд бууж байгаа нь Гэсэр ялгуусан Өгүйн хамт ертөнцөд төрдөг үлгэртэй адилавартай байна. «Баян цагаан өвгөн» туульд таван хан Хурмаст, отгон Хурмастыг баян цагаан өвгөн, бумын улаан хатан хоёрын үр нь бол гэж гэрийнх нь баруун цамхрагаар нь таван өнгийн солонго татуулан үр заяалгаж өгөөд явсан гэдэг нь Гэсэр ертөнцөд бууж эхийн хэвлийд орсон үлгэрийг санагдуулж байна. «Данххүрэл» туульд, далай хаанд ачит гурван эрдэнэ, аврагч номын сахиусан адистэдтэй олон орны эзэд бүгдээр зөвлөж нэгэн сайн хөвгүүн хайрласан зарлигийг Засучихэр гэдэг баатар ирж дамжуулж байна, Энэ бол Гэсэрийн ах Цасчихэрийн нэрийн өөр бичлэг болох нь дамжиггүй.

«Гэсэр»-ээс бусад монгол туульд ийм үлгэр үйл явдал тохиолдож байх нь нэг бол эдгээр тууль нь «Гэсэр»-ийн нөлөөг авсан, нэг бол «Гэсэр» хийгээд түүнтэй адилавартай өгүүлэмж бүхий тууль нь өөр нэг туулийн уламжлалын нөлөөг зэрэг хүртсэнтэй холбоотой байж мэднэ.

Тиймийн тулд «Гэсэр» дэх үлгэр нь өөр улс үндэстний үлгэр туулийн уламжлалаас ирэлтэй болох бололцоо, ялангуяа Энэтхэг тууль «Рамаяна» хийгээд бурхан шашны үлгэр домгоос ирсэн бололцоо маш их юм. Ер нь «Гэсэр» болон өөр монгол туульд Энэтхэг тууль «Рамаяна»-гийн нөлөө нэвтэрсэн гэдгийг эрдэмтэд зааж байсан. Жишээ нь, алдарт монголч эрдэмтэн В. Хайссиг «Алтан галав хаан» туульд «Рамаяна»-гийн нөлөө туссаныг [Хайссиг 1988: 16–17], франц эрдэмтэн Штевин түвд монгол «Гэсэр»-ийн

Шарайголын гурван хааны бүлэгт гардаг Шиманбирожагийн дүр «Рамаяна» ирэлтэй болохыг [石泰安著, 耿昇译, 陈庆英校 1980: 566–568], Оросын эрдэмтэн Неклюдовбээр Гэсэрийн дүр мөн «Рамаяна» дэх баатар Раманатай холбоотой болохыг заасан байдаг [尤涅克留多夫著, 徐昌汉、高文凤、张积智译 1991: 172]. Иймээс түвд монгол «Гэсэр» дэх үрийн хутаг гуйсан үлгэрийг Энэтхэгийн эртний тууль «Рамаяна» хийгээд бурхан шашны үлгэр домогтой харьцуулж үзэх хэрэгтэй.

#### **4. «Рамаяна»-тай харьцуулах нь**

Энэтхэг тууль «Рамаяна»-д Раманагийн ертөнцөд мэндэлсэн үлгэрийг дараах байдлаар өгүүлнэ:

1. Өтөлтлөө хаан ор залгамжлах үр хүүхэдгүй хаан олон улсыг цуглуулж тахилын мандал босгон, тэнгэр сахиулсанд морьтой тахил өргөж үрийн хутаг гуйжээ.

2. Тахил өргөхөд Эсэруа тэнгэр тэргүүлэн олон сахиусан саатсан бөгөөд тэр үед олон сахиулсан нь «Мангасын хаан улайраад тэнгэр газар гурван ертөнцийг эзлээд элдэв самуун үүсгэж байна, гучин гурван тэнгэрийн хаан Хурмастыг хүртэл дарлаж байна, тиймээс та тэр мангасыг дарж өг» хэмээн Эсэруа тэнгэрт айлтгасанд «Ертөнцийн хүний махбод бие биш болбол тэр мангасыг дарж чадахгүй учраас эрхбиш нэг сахиулсан ертөнцөд бууж, хүн болон төрвөл сая тэр мангасыг дарж болно» гэжээ.

3. Тэгээд Эсэруа тэнгэр хийгээд олон сахиусан зөвчлөөд баатар сахиусан Вишнуг ертөнцөд буулгахаар тогтсон гэнэ.

4. Тэр тогтоол ёсоор Вишну сахиусан хааны хөвгүүн болон төрөхөөр шийджээ гэнэ.

5. Хаан тахил хийж байтал нэгэн сахиусан гэнэт тахилын гал дотроос гарч ирээд хаанд нэг бутан тэнгэрийн үнээн сүү өгч, үүнийг хатандаа уулгавал дөрвөн хөвгүүнтэй болно гэжээ.

6. Хааны хатан тэр сүүг уугаад жирэмсэн болж, хөвгүүн Рамана ертөнцөд төржээ гэнэ. [23]

Үүний хамгийн гол онцлог нь гэвэл Раманагийн ертөнцөд мэндлэх үйл хэргийг хүүрнэхдээ ертөнцийн орны үйл явдал хийгээд

тэнгэрийн орны үйл хэргийг тус тус өгүүлж ам сээр нийлүүлсэнд бий. Энэ бол Монгол хийгээд Төв Азийн үндэстнүүдийн туулийн уламжлалд цөөвтөр гардаг хүүрнэлийн загвар мөн бөгөөд монгол түвд «Гэсэр» дэх Гэсэрийн ертөнцөд мэндэлсэн үлгэрийн загвартай яг таг нийлж бий. Энэ нь монгол түвд «Гэсэр», «Рамайна»-гийн нөлөөг хүртсэн гэдгийг гэрчилж байгаа хэрэг юм.

Түвд «Гэсэр»-ийг «Рамайна»-тай харьцуулж үзвэл, нэгдүгээрт, өтөлтлөө үр хүүхэдгүй хаан Эсэруа тэнгэрээс үрийн хутаг гуйсан талаар, хоёрдугаарт, тэнгэрийн сахиулсан нар хийгээд Эсэруа тэнгэр зөвчилж нэгэн сахиулсныг ертөнцөд буулгахаар тогтсон талаар, гуравдугаарт, Гэсэр ертөнцөд буухын өмнө эх болох хүнийг ертөнцөөс хайсан талаар, дөрөвдүгээрт, Гэсэр мангас шулмыг дарах үүрэгтэйгээр ертөнцөд бууж байх талаар ерөнхийдөө «Рамайна»-гийн үлгэр үйл явдалтай нийцэж байна.

Адилгүй зүйл гэвэл нэгдүгээрт, түвд Гэсэрт ертөнцийн орны үлгэр хийгээд тэнгэрийн орны үлгэр хоёрын байрыг сольжээ. Хоёрдугаарт, тахилын мандал засаж тахил өргөсөн үйл явдлыг орхижээ. Гуравдугаарт, хааны хатан тэнгэрийн сахиулсны хайрласан сүүг ууж жирэмсэн болсон үйл явдал алга байна. Дөрөвдүгээрт, Эсэруа тэнгэр хийгээд тэнгэрийн олон сахиусууд хоорондоо зөвчилж нэгэн сахиусыг ертөнцөд төрүүлэх шийдвэр гаргасныг Хоньсом бодисадваа Эсэруа тэнгэр хоёр зөвчлөн уг шийдвэрийг гаргалаа гэж өөрчилсөн байна.

Монгол «Гэсэр»-ийг «Рамайна»-тай харьцуулж үзвэл, нэгдүгээрт, Хурмаст тэнгэр гурван хөвгүүнтэйгээ зөвчилж Үйл бүтээгчийг ертөнцөд буулгахаар тогтсон талаар, хоёрдугаарт, Гэсэр ертөнцөд буухын өмнө эх болох хүнийг ертөнцөөс хайсан талаар, гуравдугаарт, Гэсэр мангас шулмыг дарах үүрэгтэйгээр ертөнцөд бууж байх талаар ерөнхийдөө «Рамайна»-гийн үлгэр үйл явдалтай нийцэж байна. Гэхдээ монгол «Гэсэр»-т бас ийм хэдэн адилгүй зүйл бий.

Нэгдүгээрт, түвд «Гэсэр»-ийн нэгэн адилаар, ертөнцийн орны үлгэр хийгээд тэнгэрийн орны үлгэр хоёрын байрыг солижээ.

Хоёрдугаарт, түвд «Гэсэр»-т үрийн хутаг гуйсан өгүүлэмж байж байтал монгол «Гэсэр»-т харин энэхүү өгүүлэмж үгүй байна.

Харин монгол «Гэсэр»-т «Хүслэн нэрт овоо»-гоор «Рамаяна» дахь тахилын мандлыг орлуулсан шинжтэй. Гэхдээ энэ нь монгол тууль дахь үрийн хутаг гуйдаг уламжлалт өгүүлэмжээс ирэлтэй бөгөөд үрийн хутаг гуйсан явдлыг балархайшуулан өгүүлсэн шиг байна.

Гуравдугаарт, Эсэруа тэнгэр хийгээд тэнгэрийн олон сахиусууд хоорондоо зөвчилж нэгэн сахиусныг ертөнцөд төрүүлэх шийдвэр гаргасныг түвд «Гэсэр»-т Хоньсом бодисадваа Эсэруа тэнгэр хоёр зөвчлөн уг шийдвэрийг гаргалаа гэж өөрчилсөн бол монгол «Гэсэр»-т чанагшлаад Шагжамуни бурханы зарлигаар Хурмаст тэнгэр хөвгүүнээ ертөнцөд буулгахаар шийдсэн болгон өөрчилжээ.

Дөрөвдүгээрт, «Рамаяна» хийгээд түвд «Гэсэр»-т байдаггүй нэгэн үлгэр, тухайлбал овоон дээр чуулсан олон сахиус ертөнцийн самууныг дарж чадах хөвгүүн энэ ертөнцөд мэндлэх эсэхийг төлгөдөж, эцэг эх нь хэн болохыг төлгөөр заасан үлгэр үйл явдал монгол «Гэсэр»-т нэмэгдэн орсон байна.

Дээрх харьцууллаар монгол түвд «Гэсэр» дэх Гэсэр ертөнцөд мэндэлсэн үлгэр адил бус хэмжээгээр Энэтхэг тууль «Рамаяна» дахь Рамана ертөнцөд мэндэлсэн үлгэрээс нөлөө авсан гэдэг нь тодорхой байна. Харин монгол «Гэсэр» дэх овоон дээр заларсан охин тэнгэр гурван төлгөчөөр Гэсэрийн мэндлэхийг төлгөдүүлсэн үйл явдлын учрыг олох гэвэл чанагшид бурхны намтар цадигийн үлгэртэй харьцуулж үзэх хэрэгтэй байна.

### **5. Бурхны намтрын үлгэртэй харьцуулах нь**

Монгол түвд «Гэсэр» дэх Гэсэр ертөнцөд мэндэлсэн үлгэр ганцхан «Рамаяна»-гаас нөлөө авсан гэж хэлэх юм бол учир дутагдалтай болно. Яагаад гэвэл монгол түвд «Гэсэр»-ийн аль аль нь ч гээд бурхны намтар цадигийн үлгэрийн нөлөөг ч гүн хүртсэн гэдгийг өнгөрсний судалгаа илрүүлээд байна. Ялангуяа монгол «Гэсэр»-т бурхны намтрын үлгэрээс ирэлтэй зүйл бишгүй олон байдаг. Зөвхөн ертөнцөд мэндэлсэн үлгэрийн талаар авч хэлэхэд тохиролцоотой зүйл үлэмж байдгийг миний бие «Бээжин барын „Гэсэр“ хийгээд бурхны намтар цадигийн үлгэрийн харьцааг өгүүлэх нь» гэдэг өгүүлэлдээ олон жишээгээр нотлон өгүүлсэн билээ [斯钦巴图 2014: 102–109]. Энд бид нэлээд бүдүүвч загварын

талаас Гэсэрийн ертөнцөд мэндэлсэн үлгэрийг бурхны ертөнцөд мэндэлсэн үлгэртэй харьцуулж үзье.

Шагжамуни бурхан ертөнцөд мэндэлсэн үлгэр мөн ерөнхий загварын хувьд тэнгэрийн орон дахь үлгэр хийгээд ертөнцийн орны үлгэр хэмээх хоёр хэсгээс бүрэлдэх бөгөөд энэ хоёр хэсгийг адил бус судруудад солбицуулан өгүүлдэг.

1. Бурхан багш ертөнцөд мэндлэхийн өмнө Дивангар бурхан, эндээс нэгэн галба илүү болсны дараа бурхан Кабалиг балгасны оронд төрөх больё уу, «Махамаяа охин тэнгэр хэмэгдэхүй ину эхэ ин буюу. Судадани хаан хэмэгдэхүй ану эцэг буюу» гэж Вивангирид үзүүлдэг [Монгол Ганжуур, 47: 236].

2. Шагжамуни бурхан ертөнцөд мэндэхийн өмнө Түшид тэнгэрийн орон дахь дамбадүгээр бодисадваа байжээ. Ертөнцийн хүмүүс ном сонсохын тул түшидийн оронд одож үл чадах хийгээд тэнгэр нар ном сонсохын тул ертөнцөд одож чадахыг харгалзан, өөрийн ертөнцөд төрж ном дэлгэрүүлэн, илт туулсан бурхан болохоор шийджээ.

3. Тэгээд Түшидийн орны бодисадваа нар хийгээд тэнгэрийн хөвгүүдийн чуулган болж, бурхан чухам хаа ямар хүний хөвгүүн болон төрөх тухай хэлэцжээ. Тэгээд язгуур (хаан язгуур), орон тив (замбуутив), цаг (ертөнцийн хүн зуу наслах цаг), уг үндсэн (долоо долоон үе хүртэл гэм явдалгүй уг үндсэн), эхнэр (эгэл доод эхнэр бус, бурхны эх болох гэж ерөөл тавьсан эхнэр) таван зүйлийн баримжаагаар сонголт хийж хамгийн сүүлд Судадани хаан хийгээд Махамаяа хатан хоёрын хөвгүүн болж төрөхөөр шийджээ.

4. Ямар дүрээр эхийн умайд орох тухай зөвтөлцсөний дүнд зургаан соёот цагаан зааны дүрээр эхийн умайд орохоор тогтжээ.

5. Дараа нь, бурхан эхийн умайд орсон үлгэрийг өгүүлнэ. Махамаяа хатан зуны дунд сарын тэргэлийн урьд долоон хоногоос нангадурт наадан жаргаж байгаад долоон хоногийн эцэст байшингийн дотор орж орон дэвсгэр дээр хэвтэж байгаад, задар махранз ирж орон дэвсгэртэй нь өргөж аваад ерэн барааны маншилагийн дээр тавьж, тэндээс анабад далайд аваачиж ариулан угаагаад, мөнгөн уулны дотор алтан жимс харшийн тэнгэр нарын орон дэвсгэрт хэвтүүлж байтал бурхан бээр зааны дуун дуурьсхан эхийг хэвлийд оржээ хэмээн зүүдэлжээ.

6. Тэр зүүдийг жаран дөрвөн бярманаар дайлуулсанд, хатны хэвлийд богд хөвгүүн оржээ, тэрбээр хэрэв гэрт аваас Чаграварди хаан болох, гэрээс гарч тойн болбоос бурхан больё уу гэжээ.

Махамаяа хатан Лумбиний цэцэглэгт нярайлах болж, бурхан эхийн умайгаас төрсөн гэдэг. Тэгэхэд Эсэруа алтан тороор бурхныг тосож авсан бөгөөд, бурхан бас номын тавцангаас ном номлогч буух мэт, шатнаас буугч төрөлтхтөн мэт хоёр гар хийгээд хоёр хөлөө сунгаж төрсөн аж. Төрмөгц тэнгэрээс хоёр урсгал усан бууж эх хөвгүүн хоёрыг ариулсан бөгөөд бурхан бээр арван зүгийг анхааран үзэж арслангийн дууг дуурьсгажээ. Бас бурхан төрмөгцөө их эм болон төрсөн, хамгийг гэтэлгэн төрсөн, энд төрсөн гурван төрөл дур умайгаас төрөх домгийг өгүүлэх бөгөөд хамгийг гэтэлгэн төрсөн төрөлдөө өглөг өгөхийн дүрээр баруун гараа сунган төрж, энд төрсөн төрөлдөө арслангийн дуу гарган төрөх аж [Монгол Ганжуур, 47: 222–272].

Дээрх бол «Цадигийг тэргүүлэн өгүүлэхүй» нэрт сударт гарах үлгэр. Бурхны намтрыг нэлээд дэлгэрэнгүй өгүүлсэн «Хутагт ахуй ихэд цэнгэсэн нэрт их хөлгөн судар»-т, урьдаар түшид тэнгэрийн оронд бодисадваа ертөнцөд буух тухай шийдвэр гаргаж, тэр орны бодисадваа нар хийгээд тэнгэрийн хөвгүүдийн чуулганаар бурхан хаа ямар хаан хатны хөвгүүн болох, ямар дүрээр эхийн умайд орох тухай зөвтсөн сонгосон зэрэг үлгэрийг өгүүлээд, дараа нь Судадани хаан Махамаяа хатан хоёрын тэнд үлгэр шилжиж, Махамаяа хатан зургаан соёот цагаан заан хэвлийд орж байхаар зүүдлээд жирэмсэн болсныг тушаагаад, дараа нь бурхны ертөнцөд мэндэлсэн ба бурхан мэндлэхтэй сацуу зуун нялх хөвгүүд, хорин мянган заан, таван зуун сайн язгууртан нярайлж, ясандарь тэргүүтэн түмэн охид мэндлэн, найман зуун шивэгчин, таван зуун эр тугал тэргүүтэн дагалдан төрснийг өгүүлнэ [Монгол Ганжуур, 61: 1–76]. Энэ нь мөн ч тэнгэрийн орны үлгэр хийгээд ертөнцийн орны үлгэр хоёр хэсгээс бүрэлдэж байна.

Түвд «Гэсэр»-ийг бурхны намтрын үлгэртэй харьцуулж үзвэл тохиролцмоор зүйл ийм хэд байна. Нэгдүүгээрт, Гэсэр тэнгэрийн орноос буусан нь бурхан Түшид тэнгэрээс буусантай адилавартай байна. Хоёрдугаарт, Гэсэр ертөнцөд буухын өмнө

ертөнцөд эх болох хүнийг хайж тогтоосон талаар адилавартай байна. Гуравдугаарт, Гэсэрийн эх олон дагинас нэгэн хөвгүүнийг өргөлцөн огторгуйгаас бууж ирэхийг үзмэгц ухаа алдаж унаад жирэмсэлсэн үлгэр нь Махамаяа хатан зүүд зэрэглээний дунд жирэмсэлсэн үлгэртэй баахан адилавартай байна. Өөр адил зүйл ховор.

Харин монгол «Гэсэр»-ийн үлгэрт бурхны намтартай тохиролцох зүйл түвд «Гэсэр»-ийн нэгэн адилаар тэнгэрийн орноос буусан, ертөнцөд эх болох хүн хайсан, ухаан мэдэлгүй болж үхэхийн унаад жирэмсэлсэн ийм гурван талаар адил байхын хамт нарийн ширийн үйл явдлын талаар тохиролцоотой зүйл нэн олон байна.

Нэгдүгээрт, гурван төлгөч төлгө орхиод, Гэсэр Гарав Донров нэртэй тэр төрөх бий, эцэг нь уулсын хаан Оваа Гүнжид энэ болох, энэ нь Гэү баяны охин Гэгсэ Амаржил болох гэж төлгөдсөн нь Шагжамуни бурхан ертөнцөд мэндлэх тухай Тивангара бурхны айлдсантай нэгэн адил байна.

Хоёрдугаарт, Бээжин барын «Гэсэрийн тууж»-д Гэгсэ Амаржил шинийн наймны шөнө түлээ түүж байгаад жирэмсэлсэн нь «Зуны дунд сарын тэргэлийн урьд долоон хоног»-т бурхны эх Нангадарын найраар эхлэн жаргаад арван тавны өдөр бурхан эхийн хэвлийд орсон гэдэгтэй холбоотой. Тэргэл гэдэг нь арван тавныг заасан нь лавтай. Тэгвэл тэргэлийн өмнө долоон хоног гэдэг нь яг шинийн найман болж гарна. «Гэсэрийн тууж»-д Гэсэр эхийн хэвлийд орсон өдрийг шинийн наймны шөнө гэж, ертөнцөд гийсэн өдрийг арван таван гэж байх нь бурхны намтар дахь тэр хоёр өдөртэй холбоотой байж болох юм. Ер нь «Гэсэрийн тууж»-д өдөр сарыг төдий л тодорхой тушаадаг үйл хэрэг туйлын цөөн байдгийг ч бодолхийлж болно.

Гуравдугаарт, Гэгсэ Амаржил хээр нэгэн их хүнтэй учралдаж үхэхийн унаад, сэргэсний дараа мөрөөр нь мөшгиж их хадны хөндийд очоод, тэр их хүн нь алтан ширээн дээр барс цоохор тугтай барс цоохор малгайтай, барс цоохор дээлтэй, барс цоохор гуталтай, алтан ширээний мөг түшиж сууж, барс цоохор сахлаа хярах арчиж сууж, энэ шөнө алжаахын муугаар алжаав би гэж

байхыг харсан нь, бурхны намтарт Задар Махранз Махамаяаг мөнгөн уулын доторх алтан жимс харшид аваачин, тэнгэр нарын орон дэвсгэр дээр хэвтүүлж байтал бурхан эхийн хэвлийд орсон гэдэгтэй тохиолцоотой байна. Үүнд уул дотор байдаг нь бүр адил, харин «Гэсэрийн тууж»-д мөнгөн уулыг нь энгийн уул болгож, алтан жимс харшийг нь хадны хөндий болгон хувируулж, тэнгэр нарын орон гэдгийг нь алтан ширээ гэж өөрчилсөн бололтой байна.

Дөрөвдүгээрт, Гэсэр эхийн хэвлийгээс ёст хүрднээр гарахдаа элээ шумнусыг тас хялайхын тулд баруун нүдээ гилийж, энэ заяан тэр заяан хоёрыг тэгш харахын тулд зүүн нүдээ харж, эсэргүүлэгч бүхнийг тас далайхын тулд баруун гараа далайж, бүгдийг эзлэн барихын тул зүүн гараа атгаж, шашныг мандуулахын тул баруун хөлөө дээш өргөж, тэрс буруу номтныг доройтуулан гишгихийн тул зүүн хөлөө жийж, догшин шумнасын сүрийг тас залгихын тулд дөчин таван дун цагаан шүдээ зуусаар төрсөн гэдэг нь, бурхан хамгийг гэтэлгэн төрсөн төрөлдөө өглөг өгөхийн дүрээр баруун гараа сунган төрж, энд төрсөн төрөлдөө арслангийн дуу гарган төрөх зэрэгтэй адилавартай байна.

Тавдугаарт, Гэсэрийг мэндэлж байхад гаднах мал адгуусан нь цугаар хээлтэж, удалгүй хонь, гүү, үхэр нь төллөсөн ба нохой нь гөлгөлсөн гэдэг нь, бурхан мэндлэх үед олон хүүхэд, Ясандарь тэргүүлэн түмэн охид мэндэлсэн, хорин мянган заан, таван зуун эр тугал тэргүүтэн дагалдан төрсөн гэдэгтэй тохиролцоотой байна.

Зургадугаарт, бурхны намтрын үлгэрт, үрийн хутаг гуйсан үйл явдал байхгүйтэй нэгэн адил, монгол «Гэсэр»-г ч үрийн хутаг гуйсан үйл явдал байхгүй. Гэтэл «Хүслэн нэрт овоон»-ы чуулганаар үрийн хутаг гуйсан үйл хэргийг балархайшуулан хэлсэн шинжтэй. Балархайшуулан өгүүлсэн нь бурхны намтрын үлгэрээр уг үлгэрийг дахин өөрчилсөнтэй холбоотой. Хурмаст тэнгэрийн хөвгүүн бурхны зарлигаар ертөнцөд буухаар тогтчихсон байдал дор, ертөнцийн хүмүүс овоо тахиж уул усны эзэд сахиус хийгээд дээд тэнгэрээс үрийн хутаг гуйснаар Гэсэр ертөнцөд мэндэллээ гэсэн өгүүлэмжийг үлдээвэл, бурхны зарлигийг дагасан хийгээд үрийн хутаг гуйсан хоёр нь зөрчилтэй зүйл болж үлдэх нь мэдээж. Тиймээс ийм зөрчлийг устгахын төлөө, бурхны намтарт

улам ойртуулах зорилгоор үрийн хутаг гуйсан үйл явдлыг зориуд балархайшуулсан гэж ойлгох нь учир ёсонд нийцэх биз ээ. Үүнээс үзэхэд, түвд «Гэсэр»-г бодвол монгол «Гэсэр»-ийн үлгэр нь бурхны намтрын үлгэрийн нөлөөг илүү хүртсэн байна.

## 6. Дүгнэлт

Монгол түвд «Гэсэр» дэх Гэсэр ертөнцөд мэндэлсэн үлгэрийг энэтхэг тууль «Рамаяна» хийгээд бурхны намтрын үлгэртэй харьцуулж үзсэний дүнд ийм хэдэн зүйл хураангуйлж болно:

Нэгдүгээрт, монгол түвд «Гэсэр»-т Гэсэрийн мэндэлсэн үлгэрийг тэнгэрийн орон дахь үлгэр болон ертөнцийн орны үлгэр хоёр хэсэг болгон хэлдэг нь Энэтхэг тууль «Рамаяна»-гийн нөлөөг ихэд авсан, түүний хүүрнэлийн дэс дарааг байрыг нь сольж ашигласантай холбоотой. Ялангуяа түвд «Гэсэр»-т ертөнцийн орны үр хүүхэдгүй хаан хатан хоёр тэнгэрийн сахиуснаас үрийн хутаг гуйсан үлгэрийг үлдээж байхаараа «Рамаяна»-гийн нөлөөг илүү хүлээсэн болох нь мэдэгдэж байна.

Хоёрдугаарт, монгол түвд «Гэсэр» дэх Гэсэрийн мэндэлсэн үлгэрт зөвхөн «Рамаяна»-гийн нөлөө туссан бус, харин бурхан шашны нөлөө, ялангуяа бурхны намтрын үлгэрийн нөлөө ч туссан байна. Гэхдээ түвд «Гэсэр» бурхан шашны нөлөө авсан боловч, тохиролцоотой зүйл маш цөөн, харин монгол «Гэсэр»-т бурхны намтрын үлгэртэй тохиролцох зүйл нэн үлэмж байх нь монгол «Гэсэр» бурхны намрын үлгэрийн нөлөөг илүү авсан болохыг харуулж байна.

Гуравдугаарт, монгол «Гэсэр» дэх Хүслэн нэрт овоон дээр чуулган чуулсан өгүүлэмж гурван талын ирэл гаралтай бөгөөд тодруулж хэлбэл монгол тууль дахь овоо тахиж үрийн хутаг гуйдаг уламжлалт үйл явдал, «Рамаяна» дахь тахилын мандал засаж үрийн хутаг гуйсан өгүүлэмж болон бурхны намтар цадигийн үлгэр дэх Диваангар бурхан Шагжамуни бурхан ертөнцөд мэндлэх тухай айлдсан гурвыг нийтгэн өөрчилсөн өгүүлэмж мөн. «Хүслэн нэрт овоо» нь «Рамаяна» дахь «Тахилын мандал»-тай тохиролцох зүйл. «Рамаяна»-гийн нөлөөг ихэд үлдээсэн түвд «Гэсэр»-т үрийн хутаг гуйсан үйл явдлыг ил бөгөөд дөхмөөр хүүрнэдэг бол,

бурхны намтрын үлгэрийн нөлөөг ихэд авсан монгол «Гэсэр»-т харин бурхны намтрын дагуу үрийн хутаг гуйсан үйл явдлыг балархайшуулан, Хүслэн нэрт овоон дээр төлгөчид төлгө татаж Гэсэрийн мэндлэхийг хүссэн, айлдсанаар орлуулан гаргасан байна.

Дөрөвдүгээрт, «Гэсэр»-ээс бусад монгол туульд бас үр хүүхэдгүй хаан хатан хоёр тэнгэр уул хайрхнаас үрийн хутаг гуйхад бурхан тэнгэр нар хоорондоо зөвчилж, эсвэл тэнгэр хурмаст өөрөө эзэн мэдэж нэгэн сахиусныг тэр хаан хатны хөвгүүн бол гэж томилж явуулдаг үлгэр үйл явдал гардаг нь «Рамаяна»-гийн үлгэр эрт дээр үед монголчуудын дотор дэлгэрэн монгол баатарлаг туулийн уламжлалыг нөлөөлж, чанагшлаад «Гэсэр»-г нөлөөлж байсантай холбоотой биз ээ. Харин монгол туульд үргэлж гардаг алтай хангайн оройд арван гурван овоо босгож үрийн хутаг гуйдаг уламжлалт үйл явдал нь Энэтхэгийн тууль үлгэр дэх үрийн хутаг гуйдаг үлгэрийн загварыг хүлээн авахад ул суурь нь болсон байна.

### Ном зүй

- Дамринжав 1997 — *Балжаан Дамринжав*. Алдуузай мэргэн. Үрэмч: Жинжааны ардын хэвлэлийн хороо, 1997.
- Дамринжав 2006 — *Балжаан Дамринжав*. Ойрадын баатарлаг үлгэрийн судлал. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо, 2006.
- Замлин сенчиний... 1959 — Замлин сенчиний намтар оршив / Ринчений хэвлэлд бэлтгэсэн. Улаанбаатар: БНМАУ-ын Шинжлэхүй ухаан ба дээд боловсролын хүрээлэнгийн хэвлэл, 1959.
- Монгол Ганжуур, 47 — Монгол «Ганжуур»-ын 47-р боть буюу «Элдэв билиг барамид»-ын «Цадигийг тэргүүлэн өгүүлэхүй» нэрт сударт бий. Хуудасны дугаар хоёр зуун гучин зургаа, дээд.
- Монгол Ганжуур, 61 — Монгол «Ганжуур»-ын 61-р боть буюу «Элдэв»-ын судрын хоёрдугаар ботийн «Хутагт ахуй ихэд цэнгэсэн нэрт их хөлгөн судар», хуудасны дугаар нэгээс далан зургаа хүртэл.
- Парчин 1972 — *Парчин М.* Данихүрэл // Аман зохиол судлал. Улаанбаатар: Шинжлэх ухааны академийн хэвлэх үйлдвэр, 1972. X. 196–201.
- Ринчиндорж 2007 — *Ринчиндорж нар*. Монгол баатарлаг туулийн чуулган. 2-р боть. Бээжин: Үндэстний хэвлэлийн хороо, 2007.
- Хайссиг 1988 — *Хайссиг В.* Оршил // Алтан галба хаан. Хайлаар: Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо, 1988.

- Цэцэнбат 2015 — *Цэцэнбат*. «Гэсэрийн тууж» дахь бурхны зарлигийн учир // Дундад улсын монгол судлал. 2015. № 3. X. 71–76.
- 斯钦巴图 2014 — 斯钦巴图:《北京木刻本〈格斯尔〉与佛传关系论》,《民族艺术》2014年第4期(总第120期),第102–109页。
- 李连荣著 — 李连荣著:《格萨尔学刍论》,北京:藏学出版社,第27页。
- 海希西著、赵振全译 1984 — 海希西著、赵振全译:《从岩石里诞生和对山的崇拜》,中国社会科学院少数民族文学研究所编:《民族文学译丛》第二集史诗专辑(二),北京,1984年,第164–181页,(内部编印)。
- 王沂暖、华甲翻译 1981 — 王沂暖、华甲翻译:《格萨尔王传(贵德分章本)》第1页,甘肃人民出版社,1981年。
- 石泰安著,耿昇译,陈庆英校订2005 — 石泰安著,耿昇译,陈庆英校订:《西藏史诗和说唱艺》,北京:中国藏学出版社,2005年,第566–568页。
- 蚁垤著,季羨林译 2016 — 【印度】蚁垤著,季羨林译:《罗摩衍那》,第一卷《童年篇》,长春:吉林出版集团股份有限公司,2016年,第47页。
- 谢尤涅克留多夫著,徐昌汉、高文凤、张积智译 1991 — 谢尤涅克留多夫著,徐昌汉、高文凤、张积智译:《蒙古人民的英雄史诗》,呼和浩特:内蒙古大学出版社,1991年,第172页。